

ДЭВШИХ ШАЛГАЛТ-2024

МОНГОЛ ХЭЛ-МАТЕМАТИК НЭГДМЭЛ АГУУЛГА III АНГИ

АЙМАГ.....
СУРГУУЛЬ

АНГИ.....БҮЛЭГ.....

ОВОГ.....

НЭР.....

- Санамж: Шалгалт 60 минут үргэлжлэх тул цагаа сайтар төлөвлөж, зөв хуваарилан, бүх даалгаврыг гүйцэтгээрэй
- Монгол хэл, математик хичээлийн агуулгаас бүрдсэн байна
- Шалгалтын материал нь сонгох хариулт бүхий тест, задгай хэлбэрийн даалгавруудаас бүрдэнэ
- Сонгох хариулттай даалгаврууд тус бүр 1 оноотой байна

БАТЛАВ

ЗАХИРАЛ

В.АЛТАНСУВД

ХЭРЛЭН СУМЫН 11 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН
3 ДУГААР АНГИЙН МАТЕМАТИК-МОНГОЛ ХЭЛ СУДЛАГДАХУУНЫ НЭГДМЭЛ
АГУУЛГЫН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ МАТЕРИАЛ

Хугацаа- 60 минут Огноо: 2024.06.05 Анги Сурагчийн нэр

МОНГОЛ ХЭЛ А хувилбар Нийт 18 оноо

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: Сонгох даалгавар бүр 1 оноотой

Унших чадварыг үнэлэх даалгавар: Эхийг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй

Хар бяруу

Үхрийн зэлний хажуугаар гарч явтал хар бяруу маань цаашаа хараад хэвтэж байна. Энэ бол жижиг биетэй, духны нь үс нүдээ бараг тагличихсан, нүд нь үзэгдэхгүй байх гэж бодогдмоор сарлагийн бяруу. Хүнээр бол их хөмсөгтэй гэж хэлж болохоор. Догшин гэж жигтэйхэн, бас их чадалтай. Би барих гэж бугуйлдаад тогтоож дийлээгүй юм.

Нэг өдөр Бэгзжав ахаар бариулж байж мордоод, булгихад нь тэсэлгүй үнсэн дээр ойчсон билээ. Гэсэн мөртлөө би унаж номхруулахсан гэж их хорхойтно.

Энэ өглөө их сэжиглэнгүй хэвтээд байхаар нь мярааж очоод ухасхийн мордлоо. Гэтэл намайг тас гэдрэг нь харуулж, тархиар минь унагачхаад бах нь харсан янзтай нуруугаа хотойлгож суниагаад явчихлаа.

Би сургуульд явахдаа хар бяруугаа аавдаа захих гэсэн юм. Гэвч ийм том хүнийг бяруу сургаад байгаарай гэлтэй ч биш тул:

- Хойтон намайг ирэхэд миний хар бяруу их л тос болчихсон байх даа гэж хэлэв.
- Тэгэлгүй яах вэ гэснээс өөр үгийг аав хэлсэнгүй.

1. Хүүгийн бяруу ямар амьтны юуны төл вэ?

А. Үхрийн Б. Сарлагийн В. Адууны Г. Хонины

2. Хар бярууг яагаад барьж унахыг хүсээд байсан бэ?

А. Том болгох гэж Б. Эрхлэн тоглох гэж В. Номхруулахсан гэж

3. “Бах нь ханасан” гэдэг үгний утгыг олоорой

А. Алдааг нь тохуурхсан Б. Унагасандаа гэмшсэн

В. Найз болсондоо баяртай байсан Г. Уурласан

4. Дараах үгсээс зөв бичсэн үгийг олоорой

А. Сарлагыг Б. Сарлагийг В. Сарлагаыг

Бичих чадварын үнэлэх даалгавар:

5. Цэгийн оронд нөөж бичээрэй.

Бяруу (хэдэн?).....настай вэ?

Бяруу хаана хэвтэж байсан бэ?

.....

6. Хар бярууны эзэн хүүд хандаж өөрийн бодлоо бичээрэй.

.....
.....
.....
.....

МАТЕМАТИК

1. Цэг ямар тоон дээр байрласан байна вэ?



A. 2

B. 1

C. -1





D. -2

2. 1м туузын будаагүй хэсгийн хүртвэр, хуваарийг зөв тэмдэглэсэн хэсгийг олоорой. Хэр




- A. $\frac{4 \text{ хүртвэр}}{7 \text{ хуваарь}}$ B. $\frac{3 \text{ хүртвэр}}{7 \text{ хуваарь}}$ C. $\frac{3 \text{ хуваарь}}{7 \text{ хүртвэр}}$ D. $\frac{7 \text{ хүртвэр}}{7 \text{ хуваарь}}$

3. Өгсөн биетийн дэлгээсийг аль дүрсүүдээр хийх вэ?




4. Гуравдугаар ангийн охидын хамгийн их тоглодог төрөл юу вэ?




- A. хөл бөмбөг
- B. ширээний бөмбөг
- C. сагсан бөмбөг
- D. гар бөмбөг

5. Дараах саванд 500 мл шингэн нэмбэл эзлэхүүн ямар хэмжээтэй болох вэ?. / 2оноо /



.....

6. Хүү хашаанд байсан амьтдыг хүснэгтэд бүртгэв. Тахиа болон туулайны тоог баганан диаграммаар дүрсэлжээ. Галуу, тооройн тоог гүйцээж дүрслээрэй /3 оноо/



БОЛОВСРУУЛСАН: СУРГАЛТЫН МЕНЕЖЕР А.МӨНХЦЭЦЭГ

БАТЛАВ

ЗАХИРАЛ

В.АЛТАНСУВД

ХЭРЛЭН СУМЫН 11 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН 2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН
3 ДУГААР АНГИЙН МАТЕМАТИК-МОНГОЛ ХЭЛ СУДЛАГДАХУУНЫ НЭГДМЭЛ
АГУУЛГЫН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ МАТЕРИАЛ

Хугацаа- 60 минут Огноо: 2024.06.05 Анги Сурагчийн нэр

МОНГОЛ ХЭЛ Б хувилбар Нийт 18 оноо
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: Сонгох даалгавар бүр 1 оноотой

Унших чадварыг үнэлэх даалгавар: Эхийг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй

Их хотыг зорьсон хоёр мэлхий

Бяцхан тосгонд амьдардаг хоёр мэлхий алс холын их хотод очихыг их хүсдэг байжээ. Тэд урт хугацааны турш аяллаа ярьж байгаад нэг л өдөр аян замдаа гарахаар болж гэнэ.

Халуун өдөр байсан тул тэд амархан ядарчээ. Жаахан явж байгаад нэг нь нөгөөгөөсөө “Хоёулаа хот руу ойртчихсон байх аа. Чи хот харж байна уу? гэж асуулаа.

- “Үгүй ээ. Гэхдээ чиний нуруун дээр гарчихвал харж чадах байх” гээд нуруун дээр нь гараад урагш харлаа. Толгой нь хойшоо гэдийсэн учраас тэр зөвхөн хойно нь үлдсэн зүйлийг буюу саяхан орхисон тосгоноо л харав.
- “Чи хот харж чадаж байна уу?” гэж нуруун дээрээ гаргасан мэлхий асуухад
- “Тийм ээ. Би харж байна. Гэхдээ яг л манай тосгон шиг харагдаж байна” гэж хариуллаа.
- “Тэгвэл манайхантай адилхан газар луу ийм халуунд эцэж цуцан явах хэрэг байна уу” гээд тэр хоёр тосгон руугаа буцав. Хариад бусад мэлхийнүүддээ ч бас хот яг л тэдний тосгон шиг жижигхэн юм байна гэж хэлж гэнэ.

1 Мэлхийнүүд хаана амьдардаг байсан бэ?

А. Хотод Б. Тосгонд В. Цөөрөмд

2. Мэлхийнүүд хаашаа явахыг хүссэн бэ?

А. Өөр тосгон руу Б. Далай руу В. Хот руу

3. Мэлхий яагаад хотыг тосгонтой нь адилхан юм байна гэж бодсон бэ?

А. Харж байсан зүйл нь өөрийнх нь тосгон байсан учраас
Б. Хот жижигхэн байсан В. Хот тосгон 2 зэрэг байгуулагдсан

4. Дараах үгсээс зөв бичих дүрэм баримтлан бичсэн үгийг олоорой

А. Очхыг Б. Гарахаар В. Тосгонд

5. Мэлхийнүүд яагаад амархан ядарсан бэ? Бүтэн өгүүлбэрээр хариулж бичээрэй.

6. Мэлхийнүүдэд хандаж өөрийн бодлоо бичээрэй.

МАТЕМАТИК Нэгдүгээр хэсэг: Сонгох даалгавар бүр 1 оноотой

- Диаграммыг уншиж тоон үзүүлэлтийг бичин зүй тогтлыг олоорой. / 2 оноо /



- Бямба, ням гарагийн тоон үзүүлэлтийг диаграммаар илэрхийлэн зурж үзүүлээрэй.
/1оноо /

БОЛОВСРУУЛСАН: СУРГАЛТЫН МЕНЕЖЕР А.МӨНХЦЭЦЭГ

ХЭРЛЭН СУМЫН 11 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН 2023-204 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 3 ДУГААР АНГИЙН АНГИ ДЭВШИХ ҮНЭЛГЭЭНИЙ ДААЛГАВРЫН СХЕМ

Даалгаврын №	Суралцахуйн зорилт	Үнэлгээний зорилт	А хувилбар	Б хувилбар	Оноо	Онооны тайлбар
Монгол хэл						
НЭГ. УНШИХ ЧАДВАРЫН СОНГОХ ДААЛГАВАР						
1	3.1б. Уншсан эх, үлгэр, өгүүлэг, шүлгээс чухал хэсгийг ялгаж, ойлгосноо харуулах 3.1г.Эхээс баатрын болон зохиогчийн үгийг ялгах	Мэдлэг ойлголт	Б	Б	1	Зөв хариултыг сонгосон бол 1 оноо, буруу хариулт сонгосон бол 0 оноо, огт хариулт сонгоогүй бол Х оноо
2		Мэдлэг ойлголт	В	А	1	
3		Чадвар	А	А	1	
4		Чадвар	Б	Б	1	
БИЧИХ ЧАДВАРЫН ДААЛГАВАР						
5	3.2б Балархай эгшгийн эгшигжүүлэх үүргийг мэдэх, бичихдээ хэрэглэх	Чадвар	Бяруу хоёр настай гэж үсгээр бичнэ Үхрийн зэлний хажууд цаашаа хараад хэвтэж байсан	Халуун өдөр байсан тул амархан ядарсан	2	Хүүхэд ямар ч санааг гаргаж болно. Санаа гаргасан бол 2 оноо, буруу хариулсан бол 0 оноо, огт бичээгүй бол Х оноо
6		Хэрэглээ	Амьтан хүний хэл мэдэхгүй учраас айлгавал эсэргүүцэл үзүүлнэ. Хайрлах энэрэхийг амьтан мэддэг	Өөрийн нутаг усаа хайрлаж байх, голж болохгүй гэдэг санаа	3	
МАТЕМАТИК						
1	3.1а.10000 хүртэлх натурал тооны орны утгыг нэрлэх, тоог унших, бичих, тоон	мэдлэг ойлголт	С	Б		Зөв хариулсан хариулт бүр 1 оноо, буруу хариулсан бол 0

2	шулуун дээр цэгээр тэмдэглэх, жиших, эрэмбэлэх	Чадвар	В	Г		оноо, огт хариулаагүй бол Х оноо
3	3.3а. Харилцан эгц (перпендикуляр), зэрэгцээ (параллел) шулуун, тэгш, хурц, мохоо өнцөг, олон өнцөгт, тойрог, дугуй дүрсийг нэрлэх, ангилах, зурах, бүтээл хийх, дүрсийн тэгш хэмийн тэнхлэгийг зурах	Мэдлэг ойлголт	А	В		
4	3.4б. Ажиглалт, хялбар туршилтаар өгөгдөл, мэдээллийг цуглуулах, хүснэгтэд бүртгэх, зурган, баганан диаграммаар илэрхийлэн асуултад хариулах	Мэдлэг ойлголт	В	В		
5	3.2б. Тохирох хэрэгсэл, хэмжих нэгжийг (мм, см, дм, м, км, г, кг, ц, т, мл, л) сонгон урт, хүнд, эзлэхүүнийг (шингэний хэмжээ, савны багтаамж) хэмжих, хэмжээг жиших, баримжаалах, хэмжих хэрэгслийн хуваарийн утгыг тайлбарлах, нэг нэгжийг нөгөө нэгжээр илэрхийлэх, дүрсийн хүрээний уртыг олох	Хэрэглээ	2 л	7 см 5 мм		А. 1.5л +0.5= гэж бодсон бол 2 оноо, бруу бодсон бол 1 оноо, бодоогүй бол Х оноо Б.7см 5мм гэж бичсэн бол 2 оноо, бруу бичсэн бол 0 оноо, огт бичээгүй бол Х оноо
Задгай даалгавар						
6	3.4б. Ажиглалт, хялбар туршилтаар өгөгдөл, мэдээллийг цуглуулах, хүснэгтэд бүртгэх, зурган, баганан диаграммаар илэрхийлэн асуултад хариулах	Чадвар	9,5	35,40		А. 9, 5 дээр баганан диаграмм байгуулсан бол 3 оноо бруу байгуулсан бол 0 оноо, огт хийгээгүй бол Х оноо Б. 35,40 зүй тогтлыг олоод, баганан диаграмм байгуулсан бол 3 оноо, бруу олж, байгуулсан бол 0 оноо, огт хийгээгүй бол Х оноо

